



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говь консалтинг менежмент” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/4/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Цахим хаяг: Аудитын менежер: Цахим хаяг: Ахлах аудитор: Цахим хаяг: Аудитор: Цахим хаяг:	Т.Ган-Өлзий dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр oyuntulkhuur.u@audit.gov.mn О.Нарангарав narangarav.o@audit.gov.mn А.Дамчой damchoia@audit.gov.mn
Дорноговь аймаг 2026 он		

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.03.13 № 1-6/301

танай _____-ны № _____-т

ГОВЬ КОНСАЛТИНГ МЕНЕЖМЕНТ
ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Говь консалтинг менежмент" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн ИТХ-ын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ-ын дүрмийг шинэчлэн батлах тухай" 04/02 тогтоолоор тус байгууллагын дүрмийг дахин шинэчилж, орчин үеийн дэвшилтэт техник технологид суурилсан иргэдэд чиглэсэн нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд шатахууны зардалд 32.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 24.4 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын аргын аль нэгийг дагуу зохион байгуулна", 31.1.2-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд

4.9505281

заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын харьцуулалтын дагуу зохион байгуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		01 сарын 01	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	1,909,190.87	40,878,664.92
1.1.01	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,103,853.87	25,268,200.71
1.1.03	Авлага /НДШ авлага/	805,337.00	973,964.21
1.1.04	Бусад авлага	-	70,180.00
1.1.05	Бараа материал		14,636,500.00
1.1.08	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,909,190.87	40,948,844.92
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	983,337,350.00
1.2.01	Үндсэн хөрөнгө		962,000,000.00
1.2.02	Хуримтлагдсан элэгдэл		(72,150,000.00)
1.2.03	Бусад үндсэн хөрөнгө		23,539,500.00
1.2.04	Хуримтлагдсан элэгдэл		(1,572,150.00)
1.2.09	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		71,520,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	983,337,350.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,909,190.87	1,024,286,194.92
2.1.1.01	Дансны өглөг	9,200,000.00	9,200,000.00
2.1.1.04	ХАОАТ-ын өглөг	6,240,498.00	6,240,498.00
2.1.1.06	Бусад татварын өглөг		6,100,700.40
2.1.1.10	Бусад өглөг		889,850,000.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	15,440,498.00	911,391,198.40
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн	15,440,498.00	911,391,198.40
2.3	2.Эзэмшигчдийн өмч	1,000,000.00	72,520,000.00
2.3.01	Өмч: - төрийн	1,000,000.00	1,000,000.00
2.3.07	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		71,520,000.00
2.3.08	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(14,531,307.13)	40,374,996.52
2.3.8.01	Тайлангийн үеийн	(45,434.24)	54,906,303.65
2.3.8.02	Өмнөх үеийн	(14,485,872.89)	(14,531,307.13)
	Эзэмшигчдийн өмчийн дүн	(13,531,307.13)	112,894,996.52
2.5.20	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,909,190.87	1,024,286,194.92

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого(цэвэр)	-	324,742,240.28
3	Нийт ашиг	-	324,742,240.28
5	Хүүний орлого	-	8,912.81
8	Бусад орлого	-	324,733,327.47
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	263,734,344.95
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	891.28
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	61,007,004.05
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	61,007,004.05
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	6,100,700.41
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	54,906,303.65
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	54,906,303.65

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	-	(14,485,872.89)	(13,485,872.89)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Өмчийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	(45,434.24)	(45,434.24)
2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	1,000,000.00	-	(14,531,307.13)	(13,531,307.13)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Өмчийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	71,520,000.00	-	-	71,520,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	54,906,303.65	54,906,303.65
2025 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	72,520,000.00	-	40,374,996.52	112,894,996.52

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	324,751,153.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	8,198,470.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	316,543,770.28
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	8,912.81
1.2	Мөнгөн зарлагын дүн	-	277,047,506.25
1.2.1	Ажиллагчдад төлсөн	-	140,822,650.92
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	35,948,862.78
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	3,318,758.18
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	21,680,600.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	24,661,776.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	891.28
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	14,360,813.16
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	10,333,810.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	25,919,343.93
2.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	47,703,646.84
2.05	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	23,539,300.00
2.2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(23,539,300.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		24,164,346.84
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,103,853.9
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,103,853.90	25,268,200.71

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,077.6 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад 1,077.6 сая төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

1.Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 68.5 сая төгрөгөөр дутуу тооцсон алдааг залруулав.

2.Худалдаж авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан нийт 985.5 сая төгрөгийн хөрөнгөөр эздийн өмчийг нэмэгдүүлсэн алдааг залруулав.

3.Худалдаж авсан хөрөнгийн зардлын дүнгээр мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг нэмэх дүнгээр илэрхийлсэн алдааг залруулав.

Аудитаар 26.7 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 1.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 24.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1.2 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 26.7 сая төгрөгийн зөрчлөөс нийцлийн аудитад хамаарах 24.4 сая төгрөг, санхүүгийн тайлангийн аудитад хамаарах 2.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1.5 сая төгрөгөөр бага байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1.Томилолтоор ажиллаж байх хугацаанд 0.1 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон. Мөн хүчин төгөлдөр бус анхан шатны баримтад үндэслэн 0.8 сая төгрөгийн томилолт олгосон байна.

2.Шатахууны тайланг шалгахад ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхойгүй, баримтаар нотлогдохгүй 0.2 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.

3.2 Албан шаардлага

1.Тайлант онд шатахууны зардалд 32.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 24.4 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

2.Төрийн албан хаагчид хамаарахгүй албан тушаалтан газрын захирал Т.Гантулгад орон нутгийн нэмэгдлийг 8-12 дугаар саруудад олгосон байна.

3.3 Зөвлөмж

1.Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Цалингийн зардлыг татвар, нийгмийн даатгалын тайланд үнэн зөв тайлагнасан эсэхийг шалгахад тайлант оны 4 дүгээр сард 9 албан хаагчийн нийт 1.2 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 24 дүгээр зүйлийн 24.1.1-т “Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл ногдох цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2-т “Ажил олгогч нь орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын

бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын албан хаагчдын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тухайн сарын нийгмийн даатгалын тайланд засаж тайлагнан, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон.	1	68,516.1	1	68,516.1	-	-	1	68,516.1	-	-	-	-
Худалдаж авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр эздийн өмчийг нэмэгдүүлсэн.	1	985,539.5	-	-	1	985,539.5	1	985,539.5	-	-	-	-
МГТ-д хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг нэмэх дүнгээр илэрхийлсэн.	1	23,539.5	-	-	1	23,539.5	1	23,539.5	-	-	-	-
Дүн	3	1,077,595.1	1	68,516.1	2	1,009,079.0	3	1,077,595.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Газрын захирал Т.Гантулгад 8-12 дугаар сард орон нутгийн нэмэгдэл олгосон.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Томилолтоор ажиллаж байх хугацаанд хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон. Мөн хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар томилолт олгосон.	1	933.0	1	933.0	-	-	-	-	-	-	-	-
Ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь нотлогдохгүй 0.2 сая төгрөгийн шатахууныг үр ашиггүй зарцуулсан.	1	200.0	1	200.0	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд зарцуулсан 24.4 сая төгрөгийн шатахуунд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.	1	24,385.4	-	-	1	24,385.4	-	-	-	-	-	-

Тайлант оны 4 дүгээр сард 9 албан хаагчийн нийт 1.2 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд илүү тайлагнасан.	1	1,170.0	-	-	-	-	1	1,170.0	-	-	-	-
Дүн	5	26,688.4	2	1,133.0	2	24,385.4	1	1,170.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-